

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**2017 ОН
САЙНШАНД**

Агуулга

Дэс дугаар	Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1	Товчилсон үгийн жагсаалт	2
2	Удирдлага зохион байгуулалтын ажил	3
3	Санхүүгийн тайлангийн аудит	4
4	Гүйцэтгэлийн аудит	5
5	Нийцлийн аудит	5
6	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгат аудит	6
7	Дотоод ажил, үйлчилгээ	6
8	Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл	8
9	Санал, дүгнэлт	9

Товчилсон үгийн жагсаалт

1	АОУС	Аудитын олон улсын стандарт
2	УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
3	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
4	ТШЗ	Төсвийн шууд захирагч
5	ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
6	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
7	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
8	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
9	ҮАГ	Үндэсний аудитын газар
10	ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
11	НАГ	Нийцлийн аудитын газар
12	ДГА	Дорноговь аймаг
13	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
14	АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
15	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын дэвшүүлсэн “Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүй, бодлогын шинэтгэл, ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд 2017 онд нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилд дараах ажлуудыг гүйцэтгэлээ.


Тайлант онд 216.0 сая төгрөгийн төсөв батлагдаж 11 орон тоотой үйл ажиллагаа явуулахаас гүйцэтгэлээр 9 орон тоогоор нийт 7012 хүн/цаг ажилласан байна.

Эхний хагас жилд Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 174 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж, нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрөөр 2 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудитыг гүйцэтгэсэн, одоо аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэл болон нийцлийн 2 аудитыг хийж байна.

Аудитаар нийт 20,174.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, аудитын явцад 6,356.2 сая төгрөгийн алдааг залруулж, 77.2 сая төгрөгийн 33 төлбөрийн акт тогтоон, 2,677.5 сая төгрөгийн 37 албан шаардлага бичиж, 324 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүллээ.

Эхний хагас жилийн байдлаар акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг авч үзэхэд 18.3 сая төгрөгийн 9 төлбөрийн акт бүрэн барагдаж биелэлт 15.9 хувьтай, 1,566.4 сая төгрөгийн 13 албан шаардлага хэрэгжиж биелэлт 58.3 хувьтай, 70 зөвлөмж бүрэн хэрэгжиж 254 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Тайлант онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Орон нутгийн төсөвт нийт 33.0 сая төгрөгийн орлого оруулсан ба үүний 30.0 сая төгрөг нь тайлант оны акт, албан шаардлагынх, 3.0 сая төгрөг нь өмнөх оны актын төлбөр байна.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай болон татгалзсан дүгнэлт авсан 7 албан тушаалтан, гүйцэтгэлийн аудитаар баримт материалыг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, батлагдсан зураг төсөвгүй ажлыг ИТХ-аар батлуулсан 1 албан тушаалтанд тус

тус хариуцлага тооцуулахаар 6 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд 1 албан шаардлага хэрэгжээд байна.

II

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудитад АОУС, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаал, санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг мөрдлөг болгож ажиллалаа.

МУ-ын Ерөнхий аудиторов 2016 оны А/72 тоот тушаалыг үндэслэн 17 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 50 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 124 байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өглөө. Үүнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төвлөрүүлэн захирагчийн 14, шууд захирагчийн 103, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 6 санхүүгийн тайланг хамруулсан байна. Үүнээс аймгийн аудитын газар өөрийн хүчээр 61 байгууллагын, хувийн аудитын компаниар 113 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгүүлсэн байна /Хүснэгт №1/.

Аудитад хамрагдсан байгууллагын тоо

Хүснэгт №1

Байгууллагын нэр	Дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Нийт
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар өөрсдөө гүйцэтгэсэн	56	5	17	78
Хувийн аудитын компаниар гүйцэтгүүлсэн	68	45		113
Нийт	124	50	17	191

Дүгнэлт өгсөн байгууллагуудаас 112 байгууллагад “зөрчилгүй” дүгнэлт, 11 байгууллагад “хязгаарлалттай” дүгнэлт, 1 байгууллагын санхүүгийн тайланд “татгалзсан” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,033.0 сая төгрөгийн төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 6,356.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 28.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 57.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 7,591.1 сая төгрөгийн 304 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитыг ААГ-ын 5 аудитор, гэрээт 2 аудитор гүйцэтгэж нийт 2530 хүн/ цаг ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх талаар авсан арга хэмжээ:

Аудитаар нийт 28.4 сая төгрөгийн 25 төлбөрийн акт, 57.3 сая төгрөгийн 13 албан шаардлага, хугацаатай 304 зөвлөмжийг өгч ажилласан. Хязгаарлалттай болон

татгалзсан дүгнэлт авсан байгууллагын албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах тухай 6 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт:

Өмнөх оноос шилжин ирсэн төлбөрийн актын 3.0 сая төгрөгийн 2 акт барагдаж, 20 зөвлөмж хэрэгжсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 2017 онд тогтоосон төлбөрийн актаас эхний хагас жилд 46.1 хувь буюу 13.1 сая төгрөгийн 8 төлбөрийн акт бүрэн барагдсан, мөн 18.4 сая төгрөгийн 7 албан шаардлага хэрэгжиж, орон нутгийн төсөвт 21.8 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Төсвийн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 304 зөвлөмжөөс эхний хагас жилд 70 зөвлөмжийг хэрэгжүүлсэн. Үлдэх 234 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар 36.7 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрч бүртгэлээ.

III

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Тайлант онд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг Засгийн газраас олгосон векселийн үр дүн” сэдэвт аудитыг бүрэн гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын захиалгаар “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа, үр дүн сэдэвт аудитыг гүйцэтгэж байна.

Гүйцэтгэлийн аудитыг 2 аудитор гүйцэтгэж, нийт 928 хүн/ цаг ажилласан бөгөөд аудитаар нийт 3608.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 12.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1633.3 сая төгрөгийн 11 албан шаардлага бичиж 1889.1 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт:

Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн албан шаардлагаас 81.2 хувь буюу 1300.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 41.6 хувь буюу 5.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт бүрэн хэрэгжсэн. Тайлант онд өгөгдсөн зөвлөмж хэрэгжилтийн шатанд байна. Аудитаар 5.2 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажилласан.

IV

НИЙЦЛИЙН АУДИТ

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт” сэдэвт аудитыг бүрэн гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын захиалгаар “Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт аудитыг гүйцэтгэж байна.

Нийцлийн аудитыг 2 аудитор гүйцэтгэж, нийт 680 хүн/цаг ажилласан бөгөөд аудитаар 2,533.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 36.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 986.9 сая төгрөгийн 13 албан шаардлага бичиж, 11 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн актаас 33.9 сая төгрөгийн нэг төлбөрийн актын хэрэгжилтийн хугацаа дууссан боловч хэрэгжээгүй, 398.4 сая төгрөгийн 3 албан шаардлагын хэрэгжилтийн хугацаа дууссан боловч 247.2 сая төгрөгийн 1 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

V

АЙМГИЙН ИТХ-ЫН ЗАХИАЛГАТ АУДИТ

Аймгийн ИТХ-ын захиалгаар 2017 оны эхний хагас жилд дараах 3 аудитыг хийхээр төлөвлөсөн. Үүнд:

1. “Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит
2. “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит
3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан үйлчилгээний үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит

“Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитыг 2017 оны 09 дүгээр сард хийж дуусгахаар аудитын төлөвлөгөөг боловсруулан, хөтөлбөрийн дагуу ажиллаж байна. Тус аудитад Замын-Үүд болон Сайншанд сумдын 2014-2016 онуудад эзэмших, ашиглах, өмчлөх эрхээр олгосон газрын төлөвлөлт, олголт, хяналтыг шалгаж байна. Аудитын хөтөлбөрт тусгагдсаны дагуу аудитын гүйцэтгэлийн үе шатны ажил 2017 оны 08 дугаар сарын 20-нд бүрэн дуусч, тайлагналын ажлыг 09 дүгээр сард дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

“Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар Ханбаян зүрх хайрхан, Хамрын хийдийн цогцолборт газрын орчим тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн 2013-2016 он болон 2017 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааг шалгаж байна. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдөр дуусгахаар төлөвлөсөн.

Дээрх аудитыг нийт 4 аудитор гүйцэтгэж нийт 1344 хүн/ цаг ажилласан.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан үйлчилгээний үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 4 ба 5 дугаар саруудад хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014-2016 оны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт шалгалт хийж 2017 оны 04 дүгээр сард дууссан. Иймд тухайн сэдвээр аудит хийх нь үр өгөөжгүй гэж дүгнэсэн учир аймгийн ИТХ-д аудитын сэдвийг өөрчлөх хүсэлт тавиад байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2017 оны дотоод ажлын төлөвлөгөөндөө 8 төрлийн арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, түүний дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Дотоод ажил үйлчилгээ:

Байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Төсвийн төвлөрүүлэн захирагч буюу Ерөнхий аудиторовн орлогчтой 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулж, ажилчидтай үр дүнгийн гэрээг 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байгууллаа.

Аудитор, шинжээчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, тайлан мэдээг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд, байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдүүлж ажиллах үүднээс оны эхэнд ёс зүйн дүрмийг танилцуулж, аудит хийх тухай бүр ажилчдаас ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг гаргуулж ажиллалаа.

Байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллахад анхаарч мэдээллийн самбар шинээр хийлгэсэн, мөн аудитын тайлан, мэдээ мэдээллийг www.audit.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна. Мөн 7 хоногт хийж гүйцэтгэсэн ажлын тайланг баасан гараг бүр цахим оффист байршуулж хэвшээд байна.

Эхний хагас жилийн байдлаар дарга, тэргүүлэх аудиторовн 18 тушаал гарч, ирсэн бичиг 228 бүртгэгдэж, харилцагч байгууллага, албан тушаалтанд 509 албан бичиг явуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/59 дугаар тушаалаар байгууллагын нэр өөрчлөгдсөн бөгөөд байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг шинээр хэвлүүлж, бичиг хэрэг байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх 4 дардсыг шинээр хийлгүүлэх ажлыг зохион байгууллаа.

Батлагдсан орон тооноос 2 орон тоо дутуу ажиллаж байгаа бөгөөд сул орон тоог нөхөхөөр 2 хүний материалыг ҮАГ-т хүргүүллээ. Мөн Сангийн яамны жуух, санхүү банкны тэргүүн, төрийн хяналтын тэргүүнд 3 ажилтныг тодорхойлж холбогдох баримт материалыг ҮАГ-т хүргүүлээд байна.

Байгууллагын LandCruiser-200 маркийн автомашины шатахуун зарцуулалтын нормыг тогтоох зорилгоор Тэргүүлэх аудиторовн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/05 тушаалаар ажлын хэсэг байгуулагдан шатахуун дүүргэлт, гүйлтийг хянаж, тоолуурын заалтын зургийг авч баталгаажуулан ажиллаж байна.

Байгууллагын албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр албан хаагч, гэр бүлийн гишүүдийн дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Мөн “Эх, үрсийн баярын өдөр”-өөр албан хаагчдын хүүхдүүдийн дунд хүүхдийн дууны тэмцээнийг зохион байгууллаа.



Дотоод болон гадаад сургалт:

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд ажилтан албан хаагчид дараах сургалтад хамрагдлаа.

- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг нар хамрагдлаа.
- Аудитор Т.Ган-Өлзий ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтад 14 хоног хамрагдаж, мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн гэрчилгээг гардан авсан
- Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг, шинжээч Б.Уранбилэг нар Түшээ дээд сургуулийн эрх зүйн бакалаврын боловсрол олгох ангид суралцан, нэгдүгээр дамжааг амжилттай төгссөн.
- Орон нутгийн өмчийн газраас Сангийн яамтай хамтран ТБОНӨХБАҮХАТХ-ийн чиглэлээр зохион байгуулсан сургалтад ахлах аудитор Ц.Лүндэгмаа, аудитор Т.Ган-Өлзий нар хамрагдаж, аудитор Т.Ган-Өлзий АЗ-н сертификат авсан.

Албан харилцаа:

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 4-р хуралдаан 2017 оны 05 дугаар сарын 30-нд явагдсан бөгөөд, дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа 2017 онд хийгдсэн “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн ТАХ-ны үр дүн, үр ашиг”, “Засгийн газраас олгосон векселийн үе дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” сэдэвт аудитын дүнг танилцуулсан.

Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийхтэй холбогдуулан 2017 оны 05 дугаар сард аймгийн болон сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан мэдээг үнэн зөв бэлтгэх, 2016 онд явагдсан сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, анхаарах асуудлын талаар аудитын менежер Ч.Хэрлэнчимэг сургалт зохион байгуулсан.

Санхүүгийн тайлагнал. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтлөж, эхний хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг байгууллагын даргын А/09 тоот тушаалаар 2017 оны 06 дугаар сарын 07-12-ны хооронд зохион байгууллаа.

Тооллогоор 118.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 13.2 сая төгрөгийн бараа материал хамрагдаж, тооллогын комиссын шийдвэрээр ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан 3.2 сая төгрөгийн хөрөнгө актлах саналыг гарган аймгийн Орон нутгийн өмчийн газарт холбогдох баримт материалыг хүргүүлээд байна.

Төсвийн гүйцэтгэл. Тайлант оны эхний хагас жилд 124.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 99.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсөв 24.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн ба үүний 69 хувь нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд, 2017 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн төслийг УАГ-т хүргүүлээд байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангаж шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг Шилэн дансны тухай хуулинд заасан хугацаанд байршуулсан.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны самбарт санхүүгийн тайлан, төсвийн мэдээллийг тогтмол байршуулан ажиллалаа.

VIII

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Ерөнхий аудиторын 2017 онд дэвшүүлсэн зорилт, УАГ-ын 7 стратеги зорилтыг хангах зорилгоор байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнээс эхний хагас жилд 9 арга хэмжээг бүрэн, 7 арга хэмжээг жилийн турш хангаж ажиллахаар төлөвлөн, 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээд байна.

Тус байгууллагад 11 ажилтны орон тоо батлагдсан боловч, тайлант хугацаанд 9 албан хаагч 7012 хүн/цаг ажилласан.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА